



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


2023.04.26 № 01/354
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН ТАНАА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэсэн Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 37 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

17203... 2023... 14

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ХӨА-2023/01/НА-СТА-ТЭЗ

Мөрөн
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317
Цахим хаяг: Erdnebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114
Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Давааням Утас:92113932
Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор С.Гансүх Утас: 95908400
Цахим хаяг: Gansukhsa@audit.gov.mn
Аудитор Л.Мандахнаран Утас: 92118277
Цахим хаяг: Mandakhnaranl@audit.gov.mn
Аудитор Г.Ичинхорлоо Утас:88012671
Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 1/20


Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/75 дугаар тушаал, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаал, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аймгийн Засаг даргын төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ш.Идэрбаясгалан/-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Б.Давааням/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 сарын 26 өдөр

№ 70/2023.04.23/100А-2023/01
/НН-УТН-ТЭЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлогдсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаврын хугацаанд Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Засаг дарга ерөнхий дансаар төсвийг үр ашиггүй зарцуулсан, төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй 246,935,060 (Хоёр зуун дөчин зургаан сая есөн зуун гучин таван мянга жар) төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэгт 80,000,000 (наян сая) төгрөг
2. Хувь хүмүүст олгосон дэмжлэгт 56,320,000 (тавин зургаан сая, гурван зуун хорин мянга) төгрөг,
3. Уралдаан тэмцээний зардалд 10,836,360 (арван сая найман зуун гучин зургаан мянга гурван зуун жар) төгрөг,
4. Бусад байгууллагуудын зохион байгуулсан хурал цуглааны зардалд 39,478,700 (гучин есөн сая дөрвөн зуун далан найман мянга долоон зуу) төгрөг
5. Шагнал урамшуулалд 60,300,000(жаран сая гурван зуун мянга) төгрөг

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ...", 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.2 "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран Төрийн санд даргах төрлийн данстай байж болно..." заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын "4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засаг дарга ерөнхий дансыг цааж, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газар¹ ирүүлэх;
2. Цаашид төсвийг үр ашигтай зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, ерөнхий нягтлан бодогч Л.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 3-д, тоот Утас: 70384043

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, Тэргүүлэх аудиторын
2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн
А/Д дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	70/A2260439/ХӨА-2023/01/НА-СТА-ТЭЗ	Зөрчил арилгуулах тухай

--oo0oo--

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

БҮЛЭГ-1 ТӨСВИЙГ САНГИЙН ЯАМАНД ХҮРГҮҮЛСЭН САНАЛААС 8,945.1 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛСАН БАЙНА.

- 1.1 Орон нутгийн орлогыг бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд тулгаруулан төсвийн санал боловсруулж хүргүүлээгүй байна.
- 1.2 Төсвийн зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүйгээс төсвийн саналыг анх баталсан дүнгээс 8,945.1 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.
- 1.3 Орон нутгийн 2022 оны төсөвт 260.9 сая төгрөгийн нэмэх тодотгол, 79.5 сая төгрөгийн зохицуулалтыг хийсэн байна.

БҮЛЭГ-2 УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫГ 7,131.8 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛСЭН БАЙНА.

- 2.1 Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 6,034.5 сая төгрөгөөр буюу 27.2 хувиар давуулан биелүүлсэн байна.
- 2.2 Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь биелүүлсэн боловч, ААНОАТ-ын орлогын төлөвлөгөөг 23.6 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

БҮЛЭГ-3 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС 59,020.1 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРСАН БАЙНА.

- 3.1 Төсвийг үр ашигтай зарцуулаагүйтэй холбоотой 998.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- 3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүйтэй холбоотой 573.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Дүгнэлт:

Зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан:

Нэмэлт санхүүжилтийн тайлан:

Хавсралт:

Холбогдох байгууллагын санал:

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж Ахуй Нэгж
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ОНӨААҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Үйлдвэрийн Газар
ОНХНС	Орон Нутгийн Хөгжлийн Нэгдсэн Сан
ОНӨГ	Орон Нутгийн Өмчийн Газар
СӨБ	Сургуулийн Өмнөх Боловсрол
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ЗГНХ,	Засгийн Газрын Нөөц Хөрөнгө
ЗДНХ	Засаг Даргын Нөөц Хөрөнгө
МУ	Монгол Улс

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлогдсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийсэн.

Аудитын зорилт:

Хөвсгөл аймгийн 2022 оны орон нутгийн төсвийг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг бодитой хангуулж, үнэн зөв тайлагнасан эсэхэд аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан Хөвсгөл аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн 2022 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэлтэй эсэх
- Орон нутгийн 2022 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг бүрэн хангасан эсэх
- Орон нутгийн 2022 оны төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулсан эсэх

Аудитын хамрах хүрээ:

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэл, орон нутгийн орлого, зарлага, судалгаа, харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэл болон бусад баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 тушаалаар баталсан “Санхүүгийн аудитын журам”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмж батлах тухай”, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол улсын сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан журам.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоол
- 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 10 дугаар тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгцдэлгэр хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Давааням, аудитор С.Гансүх,

Л.Мандахнаран, Г.Ичинхорлоо нар 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Үндсэн мэдээлэл:

Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газраас ирүүлсэн ТЕЗ нарын 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар, удирдамжид заасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн болон татварын хууль тогтоомжийг мөрдөж, орлогын боломжит эх үүсвэрүүдийг дайчлах, бааз суурийг өргөжүүлэх зорилтуудыг баримтлан ажилласан байна.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд 2022 оны төсвийн жилд Хөвсгөл аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, ОНХС-д олгох шилжүүлгийг дараах байдлаар тодотгол хийж баталсан байна. Үүнд:

№	Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгол хийсэн	Зөрүү	УИХ-аас 2022 оны төсөвт тодотгол хийж, Хөвсгөл аймагт олгох санхүүгийн дэмжлэг, ОНХС-аас олгох шилжүүлгийг нийт 6,190.0 сая төгрөгөөр бууруулсан байна.
1	Санхүүгийн дэмжлэг	27,137.4	21,748.7	5,389.7	Хөвсгөл аймгийн төсвийг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн аймгийн ИТХ-ын хуралдааны 05 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн эх үүсвэрийг анх 68,102.7 сая төгрөгөөр, урсгал зардлыг 61,175.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 3,529,0 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 3,398.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.
2	ОНХС	9,623.3	8,823.0	800.3	
	Нийт	36,760.7	30,571.7	6,190.0	

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 10 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2.1 заалтыг үндэслэн Хөвсгөл аймгийн орон нутгийн 2022 оны төсөвт 260.9 сая төгрөгийг нэмэх тодотгол хийж нийт орлого, зарлагыг 68,363.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/429 захирамжаар орон нутгийн төсөвт 1 удаагийн зохицуулалтыг хийсэн байна.

Аймгийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт орлогын гүйцэтгэлийг 58,342.9 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 59,545.5 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтын дагуу тохируулсан аккруэл сууриар тайлагнасан байна.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгов.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоож, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 893.2 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Дээрх ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 669.9 сая төгрөгөөр тогтоолоо. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоогоогүй болно.

БҮЛЭГ 1: ТӨСВИЙГ САНГИЙН ЯАМАНД ХҮРГҮҮЛСЭН САНАЛААС 8,945.1 СЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛСАН БАЙНА.

1.1 Орон нутгийн орлогыг бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд тулгаруулан төсвийн санал боловсруулж хүргүүлээгүй байна

Орон нутгийн 2022 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжид заасан зарчмын хүрээнд 2022 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 12,504.7 сая төгрөгөөр боловсруулж Төсвийн тухай хуулийн 8.4.3¹-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 1/1681 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн байна. Үүнд:

- Татварын орлогыг 11,757.5 сая төгрөгөөр
- Татварын бус орлогыг 712.2 сая төгрөгөөр
- Хөрөнгийн орлогыг 35.0 сая төгрөгөөр

Сангийн яам орон нутгийн төсвийн суурь орлогыг 5,256.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 17,761.0 сая төгрөгөөр хянасан байна.

Орон нутгаас Сангийн яаманд хянуулсан суурь орлогын төсвийн төслийг аймгийн ИТХ-аас анх баталсан дүнтэй зэрэгцүүлэн харуулбал:

Орлогын нэр төрөл	2022 он			Зөрүү	Сангийн яамны хянаж ирүүлсэн орон нутгийн суурь орлогын дүнг аймаг, сумын ИТХ-аар 3,016.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.
	СЯ-нд хүргүүлсэн дүн 1	СЯ-ны хянасан дүн 2	АИТХ анх баталсан дүн 3		
1.Татварын орлого	11,757.5	16,381.0	18,675.9	2,294.9	Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө Сангийн яамны хянасан дүнгээс
2.Татварын бус орлого	712.2	1,380.0	1,381.8	1.8	
3.Хөрөнгийн орлого	35.0		720.2	720.2	
Нийт орлого	12,504.7	17,761.0	20,777.9	3,016.9	

татварын орлогыг 4,623.5 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 667.8 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна. Энэ нь Орлогыг өмнөх оны гүйцэтгэл, бодит тооцоо судалгаанд үндэслэн орлого нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчилж төлөвлөөгүйг харуулж байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,185.3 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дахь заалтад заасны дагуу улсын төсөвт дараах 8 нэр төрлийн орлогыг төвлөрүүлж байна. 2022 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 5,951.9 сая төгрөгөөр төлөвлөн баталсан байна.

Хүснэгт № 3 Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

№	Татварын төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	2022 оны төлөвлөгөө	Зөрүү
1	ААНОАТ	1,396.9	1,550.0	153.1
2	НӨАТ	5,329.7	4,000.0	-1,329.7
3	Онцгой албан татвар	93.3	85.0	-8.3
4	Ашигт малтмал/нүүрс	131.8	129.0	-2.8
5	Ус бохирдуулсны төлбөр	7.7	3.5	-4.2
6	Агаарын бохирдол /авто/	98.3	96.9	-1.4
7	Агаарын бохирдол /нүүрс/	77.5	84.5	7.0
8	Агаарын бохирдол /эх үүсвэр/	2.0	3.0	1.0
	Дүн	7,137.2	5,951.9	-1,185.3

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлэх;

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,185.3 сая төгрөгөөр багаар төлөвлөсөн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогыг 1,329.7 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөнтэй холбоотой байна.

ААН-ийн орлогын албан татварын орлогыг 2,720.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 1,170.0 сая төгрөг буюу 43.0 хувийг аймгийн төсөвт, 1,550.0 сая төгрөг буюу 57.0 хувийг улсын төсөвт хуваарилахаар тусгасан байна. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 3 хувиар буюу 18.0 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна. Энэ нь "Төсвийн тухай хуулийн 23.6.Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ... 23.6.10.аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь" заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.2 Төсвийн зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүйгээс төсвийн саналыг анх баталсан дүнгээс 8,945.1 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.

Төсвийн саналыг боловсруулан сангийн яаманд хүргүүлэхдээ анх батлагдсан төсвөөс 8,945.1 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна.

Хүснэгт № 4 Төсвийн нийт зардлын төлөвлөгөө

Зардлын үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	Төсвийн санал	Анх баталсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	Өөрчлөлт
1	2	3	4	5	3-4
А.УРСГАЛ ЗАРДАЛ	109,171.1	47,621.8	61,175.3	58,934.8	-13,553.5
Бараа ажил үйлчилгээний зардал	102,960.5	45,122.4	42,323.3	38,800.6	2,799.1
Татаас	1,855.6	122.0	1,155.5	1,267.7	-1,033.5
Урсгал шилжүүлэг	4,355.0	2,377.5	17,696.5	18,866.4	-15,319.0
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,269.8	11,097.7	3,529.0	5,761.5	7,568.7
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,124.7	438.1	3,398.3	3,667.4	-2,960.2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,565.6	59,157.6	68,102.7	68,363.6	-8,945.1

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс нь төсвийн шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэн боловсруулж сангийн яаманд хүргүүлсэн хэдий ч төсвийн саналыг зорилтод түвшинтэй харьцуулахад нийт зардлыг 9,206.0 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна.

Төсвийн зардлыг боловсруулахдаа урсгал зардлыг өмнө оны гүйцэтгэл, үнийн өсөлтөд тулгуулан бодитой тооцоогүйгээс төсвийг анх батлахдаа сангийн яаманд хүргүүлсэн төсвийн саналаас 13.2 хувиар нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд:

- Урсгал зардлыг 11,313.0 сая төгрөгөөр дутуу
- Хөрөнгийн зардлыг 5,336.2 сая төгрөгөөр илүү
- Эргэж төлөгдөх цэвэр зээлийг 3,229.3 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

Төсвийн зардлын зорилтод түвшнийг өмнөх онтой харьцуулахад 50,202.0 сая төгрөгөөр буурсан нь Тусгай зориулалтын шилжүүлгийн болон Соёл, Эрүүл мэндийн нийт 130 байгууллага улсын төсөвт шилжиж гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих болсонтой холбоотой байна.

1.3 Орон нутгийн 2022 оны төсөвт 260.9 сая төгрөгийн нэмэх тодотгол, 79.5 сая төгрөгийн зохицуулалтыг хийсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг сангийн яамны Э-тайлан программд оруулахдаа батлагдсан төсвөөс зөрүүтэй мэдээлсэн байна. Тухайлбал: Урд оны үлдэгдлээс санхүүжих дүн, орон нутгийн төсвөөс санхүүжих дүн зэргийг зөрүүтэй байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 10 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2.1² заалтыг үндэслэн 2022 оны төсөвт тодотгол хийж 260.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хөвсгөл аймгийн ТЭЗ-ийн 2022 оны төсвийн тодотгосон төлөвлөгөөг анх батлагдсан түвшинтэй харьцуулахад дараах байдалтай байна:

Хүснэгт №-5 Төсвийн тодотгол

Орлогын төрөл	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	/сая.төг/ зөрүү	
			дүн	Хувь
1 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	9,623.3	8,823.0	-800.3	8.3
2 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	27,137.4	21,748.7	-5,388.7	19.9
3 Орон нутгийн орлого	20,777.9	22,016.4	1,238.5	6.0
4 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2,232.5	2,231.0	-1.5	0.1
5 Өмнөх оны үлдэгдэл	8,331.6	13,544.5	5,212.9	62.6
Нийт орлого	68,102.7	68,363.6	260.9	0.4

Хүснэгтээс харахад: Орон нутгийн төсвийг тодотгож батлахдаа анх баталсан дүнгээс улсын төсвийн дэмжлэг 5,388.7 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 800.3 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлийг 1,394.1 сая, үйл ажиллагааны орлогыг 1.5 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн орлогыг 1,238.5 сая төгрөгөөр, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг 5,212.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Төсөвт хийсэн зохицуулалтын талаар:

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2³, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/429 дугаар захирамжаар, 1 удаа төсөвт зохицуулалт хийсэн байна. Төсөвт хийсэн зохицуулалтыг байгууллагын төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Орон нутгийн байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлаас 21.3 сая төгрөгийг хасах, СӨБ-ын байгууллагуудын байр ашиглалтын зардлаас 9.2 сая төгрөгийг, Соёлын байгууллагуудын цалингийн зардлаас 49.1 сая төгрөг нийт 79.5 сая төгрөгийн хасах, эрүүл мэндийн байгууллагуудын байр ашиглалтын зардалд 10.0 сая төгрөгийг, ЕБС-иудын байр ашиглалтын зардалд 69.5 сая төгрөг нийт 79.5 сая төгрөгийн нэмэх зохицуулалтыг хийсэн байна.

Орон нутгийн 2022 оны төсөвт 260.9 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж, байгууллагын төрлөөр авч үзвэл 79.5 сая төгрөгийн нэмэх, 79.5 сая төгрөгийн хасах зохицуулалтыг хийсэн нь холбогдох хууль, журамтай нийцсэн байна.

БҮЛЭГ 2: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫГ 7,131.8 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛСЭН БАЙНА.

2.1 Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 6,034.5 сая төгрөгөөр буюу 27.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 68,363.6 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 58,342.9 сая төгрөгийн төсвийг бүрдүүлэн ажилласан байна. Тайлант онд улсын төсвөөс орон нутагт өгөх дэмжлэгийг 432.3 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Энэ нь Мал хамгаалах сангийн зээлийн эргэн төлөлтийн 108.2 сая төгрөг, "Хөвсгөл Ус суваг" ХХК-ийн дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт 324.2 сая төгрөгийг тус тус суутгаж шилжүүлсэнтэй холбоотой байна.

² Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон
³ Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно,

Аймгийн орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл дараах байдалтай байна.
Хүснэгт №-6 Төсвийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх эх үүсвэр

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэлээр	2022 он		2022 оны биелэлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Тусгай зориулалтын шилжүүлэг	71,893.9				
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	9,641.3	8,823.0	8,812.6	-10.4	99.9
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	18,661.5	21,748.7	21,316.4	-432.3	98.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,918.4	22,172.0	25,944.0	3,927.6	117.8
Үйл ажиллагааны орлогоос		2,231.0	2,082.7	-148.3	93.4
Урд оны үлдэгдлээс		13,388.9	187.2	-13,357.3	1.4
Дүн	123,851.7	68,363.6	58,342.9	-10,020.7	85.3

Төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн 55.3 хувийг орон нутгийн төвийн орлого, 31.8 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 12.9 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг тус тус эзэлж байна.

Хүснэгт №-7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	19,365.4	24,754.2	5,388.8	127.8
Татварын бус орлого	1,586.4	2,194.1	607.7	138.3
Хөрөнгийн орлого	1,220.2	1,258.2	38.0	103.1
Нийт дүн	22,172.0	28,206.5	6,034.5	127.2

Орон нутгийн төсвийн орлогын 87.7 хувь нь татварын орлогоос, 7.8 хувь нь татварын бус орлогоос, 4.5 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

Хүснэгт №-8 орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл.

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулан хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/
2021 он	16,333.8	22,230.0	
2022 он	22,172.0	28,206.5	
Өөрчлөлт	5,838.2	5,976.5	Хүснэгтээс харахад: 2022 оны төсвийн орлогын төлөвлөлт өмнөх оноос 5,838.2 сая

төгрөгөөр, орлогын гүйцэтгэл өмнөх оноос 5,976.5 сая төгрөгөөр өссөн нь жил бүр татварын бааз суурь өсөн нэмэгдэж байгаатай холбоотой байна. Үүнд:

1. Тайлант онд орон нутгийн орлого нийт дүнгээрээ 6,034.5 сая төгрөгөөр давж биелэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутгах ХХОАТ-ын орлого 1,638.1 сая төгрөгөөр,
2. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлбөрийн орлого 3,489.9 сая төгрөгөөр
3. Торгуулийн орлогыг 517.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн байна.
/Хавсралт № 2-оос харах/

Аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 516.8 сая төгрөгөөр, сумдын орлогын төлөвлөгөөг 5,517.7 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №-9. Орлогын төлөвлөгөөний биелэлт

№	Үзүүлэлт	Нийт дүн		Биелэлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/хувь/
1	Сумдын орлогын дүн	17,869.5	23,387.2	5,517.7	130.9
2	Аймгийн орлогын дүн	4,302.5	4,819.3	516.8	112.0

Нийт дүн 22,170.0 28,206.5 6,034.5 127.2

Сумдын орлого давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Шууд бус орлого: Өмнөх оны ААНОАТ-ын суутгалын 10 хувь төлөөгүй байсныг 2022 онд нөхөн төлүүлж төвлөрүүлсэн. Үүнд: Нефть борлуулалтын “Хангай торх” компаниас 600.0 сая төгрөг, “Алтан дуулга” ХХК-аас 70 сая төгрөг.
- Ойн нөөц ашигласны төлбөр: Галт, Жаргалант, Тариалан, Эрдэнэбулган, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдад үйлдвэрлэлийн зориулалттай самар бэлтгэсний төлбөрийн орлогоос 3,400.0 сая төгрөг төвлөрсөн байна.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр: Цэцэрлэг суманд 2 шонхор шувуу барьсны хураамж, Цагаан-Уул суманд 3 шонхор шувуу барьсны хураамж /1ш шонхор шувуу 9.6\$/, Арбулаг, Баянзүрх, Рэнчинлхүмбэ, Цагааннуур, Цагаан-Уул сумдад тул загас барих зөвшөөрлийн хураамжийн 424.9 сая төгрөг төвлөрсөн.

Аймгийн хэмжээнд Арбулаг, Төмөрбулаг сумдын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 48.9 сая төгрөгөөр тасарсан нь тухайн сумдад нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна. /Хавсралт № 3-аас харах/

Орон нутгийн 26 нэр төрлийн орлогоос 19 нэр төрлийн орлого нийт дүнгээрээ 6,034.5 сая төгрөгөөр давж биелсэн байна. Орлого давж биелэхэд нөлөөлсөн орлогуудыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- **Үйл ажиллагааны орлого:** Жилийн төлөвлөгөө 511.3 сая төгрөг гүйцэтгэл 774.3 сая төгрөг. Орлого давсан шалтгаанд 2021 оны малын гаралтай түүхий эд тушаасан малчин, мал бүхий этгээдэд олгох мөнгөн урамшуулал тайлант онд орсноос тооцсон хувь хүний орлогын албан татвар гол нөлөө үзүүлсэн.
- **Шууд бус орлого:** Жилийн төлөвлөгөө 356.6 сая төгрөг, эхний 10 сарын гүйцэтгэл 992.3 сая төгрөг. Өмнөх онд суутган төлөгчийн татвараа төлөөгүй байсан ААН-үүдээс нөхөн төлүүлж төвлөрүүлсэн байна. /Нефть борлуулалтын “Хангайн торх” компаниас 600.0 сая төгрөг, “Алтан дуулга” ХК-аас 70.0 сая төгрөг/
- **Газрын дуудлага худалдааны орлого:** Жилийн төлөвлөгөө 67.4 сая төгрөг гүйцэтгэл 262.4 сая төгрөг. Төсөв батлагдах үед газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байсан тул газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг багаар баталсан болон газрыг дуудлага худалдаагаар борлуулж байгаатай холбоотой орлого давж биелсэн байна.
- **Ойн нөөц ашигласны төлбөр:** Жилийн төлөвлөгөө 1,746.9 сая төгрөг, гүйцэтгэл 4,982.9 сая төгрөг. Галт, Жаргалант, Тариалан, Эрдэнэбулган, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдад үйлдвэрлэлийн зориулалттай самар бэлтгэсний төлбөрийн орлогоос 3.4 тэрбум төгрөг төвлөрөөд байна.
- **Ан амьтны нөөц ашигласны төлбөр:** Жилийн төлөвлөгөө 181.5 сая төгрөг гүйцэтгэл 424.9 сая төгрөг. Цэцэрлэг суманд 2 шонхор шувуу барьсны хураамж, Цагаан-Уул суманд 3 шонхор шувуу барьсны хураамж /1ш шонхор шувуу 9.6\$/, Арбулаг, Баянзүрх, Рэнчинлхүмбэ, Цагааннуур, Цагаан-Уул сумдад тул загас барих зөвшөөрлийн хураамжийн орлогууд төвлөрсөн байна.
- **Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого:** Жилийн төлөвлөгөө 1,220.2 сая төгрөг гүйцэтгэл 1,258.2 сая төгрөг. Үүнээс Эмийн эргэлтийн санг дуудлага худалдаагаар борлуулсны орлогоос 1,204.0 сая төгрөг аймагт төвлөрсөн

Орон нутгийн нийт 25 төрлийн орлогоос 2022 оны жилийн эцсийн байдлаар 18 нэр төрлийн орлого давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого 1,046.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №-10 Нэр төрлөөрөө тасарсан орлого:

№	Орлогын нэр төрөл	2022 оны өссөн		Тасралтын дүн	/сая.төг/ Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Хөрөнгийн орлого	1,798.6	1,301.3	-497.3	72.3

2	ААН-ын орлогын албан татвар	1,170.0	936.0	-234.0	80.0
3	Бууны албан татвар	81.8	81.2	-0.6	99.3
4	Малд ногдуулах албан татвар	1,587.9	1,406.0	-181.8	88.5
5	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	463.8	333.2	-130.6	71.8
6	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	25.2	25.2	-0.035	99.9
7	Түрээсийн орлого	44.3	41.8	-2.5	94.4
8	Тасарсан орлогын дүн	5,171.6	4,124.7	-1,046.8	79.8

Орлого тасарсан шалтгаан, тайлбар.

- 1. Хадгаламжийн хүүгээс суутгасан татварын орлого:** Жилийн төлөвлөгөө 1,798.6 сая төгрөг, гүйцэтгэл 1,301.3 сая төгрөг буюу 497.3 сая төгрөгөөр орлого тасарч 72.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Орлого тасарсан шалтгаан нь 2022 онд иргэд банкнаас хадгаламжаа их хэмжээгээр татах болсон мөн хугацаагүй хадгаламжийн хүүгийн орлогоос татвар суутгаж аваагүй, хугацаатай хадгаламжийн хүүгийн орлого буурсан мөн хугацаатай хадгаламжийн дундаж хүү буурсантай холбоотой байна.
- 2. ААН-ын орлогын албан татвар:** Тус татварын 40 хувь болох 2022 оны жилийн төлөвлөгөө 1,170.0 сая төгрөг, гүйцэтгэл 936.0 сая төгрөг буюу 234.0 сая төгрөгөөр орлого тасарч 80.0 хувийн гүйцэтгэлтэй. Энэ татварын төлөвлөгөөг Сангийн яамнаас хэт өндрөөр хянасан тул жилийн төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй байсан байна.
- 3. Бууны албан татвар:** Жилийн 81.8 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэл 81.2 сая төгрөг буюу 594.8 сая төгрөгөөр орлого тасарч 99.3 хувийн гүйцэтгэлтэй. Зарим сумд ашиглагдахгүй буундаа хасалт хийгдээгүй мөн бууны шилжилт хөдөлгөөнөө бүртгүүлээгүй зэрэг нь тасалдалд нөлөөлсөн байна.
- 4. Малын тоо толгойд ногдуулах албан татвар:** Жилийн төлөвлөгөө 1,587.9 сая төгрөг, гүйцэтгэл 1,406.0 сая төгрөг буюу 181.8 сая төгрөгөөр орлого тасарч 88.5 хувийн гүйцэтгэлтэй. Татварын төлөвлөгөө 15 суманд тасарч, хамгийн өндөр дүнтэй нь Төмөрбулаг сум 84.1 сая төгрөгөөр, Арбулаг сум 69.2 сая төгрөгөөр, Галт 47.9 сая төгрөгөөр, Баянзүрх 30.7 сая төгрөгөөр, Ренчинлхүмбэ сум 21.8 сая төгрөгөөр тасарсан.
- 5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Жилийн 463.8 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс, гүйцэтгэл 333.2 сая төгрөг буюу 130.6 сая төгрөгөөр орлого тасарч 71.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Орлогын төсалдалд Мөрөн сумын орлогын төсалдал ихээр нөлөөлж байна. Мөрөн сумын хог хаягдлын үйлчилгээний хураамж жилийн 350.1 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс, гүйцэтгэл 229.4 сая төгрөг буюу 120.8 сая төгрөгөөр орлого тасарч 65.5 хувийн гүйцэтгэлтэй. "Хөвсгөл-Эрчим хүч" ХХК-иас Мөрөн сумын 9, 10, 11, 12 сарын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 130.0 сая төгрөгийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр шилжүүлсэн нь 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр дансанд шилжин орж ирсэн нь тасалдлыг бий болгох гол шалтгаан болсон байна.
- 6. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр:** Жилийн 25.2 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэл 25.2 сая төгрөг буюу 0.035 сая төгрөгөөр орлого тасарч 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.
- 7. Түрээсийн орлого:** Нийт 44.3 сая төгрөгийн жилийн төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэл 41.8 сая төгрөг буюу 2.5 сая төгрөгөөр орлого тасарч 94.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Бүрэнтогтох, Галт, Их-Уул, Рашаант, Тосонцэнгэл, Цэцэрлэг сүмдэд олгогдсон арьс элдэх тоног төхөөрөмжийн /үйл ажиллагаа эхлээгүй, жигдрээгүй, үнэ өндөр гэсэн шалтгаантай/ түрээсийн орлого төлөгдөөгүй.

Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл 7 нэр төрлийн орлого 1,046.8 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон өөрчлөлт, Сангийн сайдын 2022 оны А/7 дугаар тушаалаар баталсан "ААНОАТ-ын орлогыг аймаг нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам"-ын дагуу ААНОАТ-ыг улсын төсвийн орлогын

бүрэлдэхүүнд байсныг улсын төсөвт 60 хувь, орон нутгийн төсөвт 40 хувийг хуваарилахаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

1. Тайлант онд ААН-ийн орлогын албан татварын орлогыг 2,720.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 1,170.0 сая төгрөг буюу 43.0 хувийг аймгийн төсөвт, 1,550.0 сая төгрөг буюу 57.0 хувийг улсын төсөвт хуваарилахаар тусгасан байна. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 3 хувиар буюу 18.0 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.
2. Гүйцэтгэлээр ААН-ийн орлогын албан татварын орлого 2,462.4 сая төгрөгийг төвлөрүүлж 936.0 сая төгрөг буюу 38.0 хувийг аймгийн төсвийн орлого, 1,526.4 сая төгрөг буюу 62.0 хувийг улсын төсвийн орлогод хуваарилсан байна. Сангийн яамнаас аймгийн төсөвт хуваарилах санхүүжилтийг 50.0 сая төгрөгөөр буюу 2 хувиар дутуу шилжүүлсэн байна.

Аймгийн төсөвт хуваарилах ААНОАТ-ын орлогын орон нутагт ноогдох хувийг 43.0 хувиар тооцон төсөв баталж, гүйцэтгэлээр 38.0 хувиар тооцож 50.0 сая төгрөгөөр буюу 2 хувиар дутуу хуваарилсан байна. Энэ нь “Төсвийн тухай хуулийн 23.6.Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ... 23.6.10.аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” заалттай нийцэхгүй байна

2.2. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь биелүүлсэн боловч, ААНОАТ-ын орлогын төлөвлөгөөг 23.6 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

2.2.1 Хөвсгөл аймгийн 2022 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нийт 5,951.9 сая төгрөгөөр төлөвлөж 7,049.2 сая төгрөгөөр буюу 118.44 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт№-11. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт

№	Татварын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/сая.төг/ Хувь
1	ААНОАТ	1,550.0	1,526.4	(23.6)	98.48
2	Суутгасан ААНОАТ	-	232.2	232.2	-
3	НӨАТ	4,000.0	4,594.2	594.2	114.86
4	Онцгой албан татвар	85.0	156.7	71.7	184.31
5	Ашигт малтмал/нүүрс	129.0	225.6	96.6	174.92
6	Ус бохирдуулсны төлбөр	3.5	5.7	2.2	164.07
7	Агаарын бохирдол /авто/	96.9	110.9	14.0	114.46
8	Агаарын бохирдол /нүүрс/	84.5	194.5	110.0	230.12
9	Агаарын бохирдол /эх үүсвэр/	3.0	3.0	-	100.00
	Дүн	5,951.9	7,049.2	1,097.3	118.44

Аудитын илрүүлэлт:

- Хөвсгөл аймгийн 2022 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн боловч ААНОАТ-ын орлогын төлөвлөгөө 23.6 сая төгрөгөөр тасарсан байна.
- Төсвийн тухай хуульд заасны дагуу Мөрөн сумын төсөвт төвлөрөх ёстой Хаан банкны нийт хувьцаа эзэмшигчдэдээ хувьцааны ногдол ашиг олгосон орлогоос суутгасан 232.2 сая төгрөгийн ХХОАТ-ыг “Суутгасан ААНОАТ” нэрээр улсын төсөвт төвлөрүүлж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 “сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.1 дэх “хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар” заалттай нийцэхгүй байна.

БҮЛЭГ 3: ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС 59,020.1 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРСАН БАЙНА.

3.1. Төсвийг үр ашигтай зарцуулаагүйтэй холбоотой 1,010.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Хөвсгөл аймгийн 2022 оны зардлын төлөвлөгөө 68,363.6 сая төгрөг, гүйцэтгэл 59,545.5 сая төгрөг буюу 87.1 хувьтай байна. Төсвийн зардлын гүйцэтгэл 59,343.9 сая төгрөг ба өмнөх онтой харьцуулахад 50 хувь буюу 59,218 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №-12. Төсвийн гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр харуулбал:

Зардлын үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны нэгтгэсэн тайлангаар				Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү		
А.УРСГАЛ ЗАРДАЛ	109,171.1	58,934.8	52,475.5	-6,459.3	89.0	
Бараа ажил үйлчилгээний зардал	102,960.5	38,800.6	37,180.3	-1,620.3	95.8	
Татаас	1,855.6	1,267.7	1,267.7	0.0	100.0	
Урсгал шилжүүлэг	4,355.0	18,866.4	14,027.6	-4,838.8	74.4	
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,269.8	5,761.5	4,997.8	-763.7	86.7	
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЭЗЭЛ НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭЗЭЛИЙН ДҮН	1,124.7	3,667.4	2,072.1	-1,595.3	56.5	
	118,565.6	68,363.6	59,545.5	-8,818.1	87.1	

Хүснэгт 13. Орон нутгийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг аймаг, сумаар харуулбал:

№	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Үүнээс:		
					Эргэж төлөгдөх зээл	Хөрөнгийн зардал	Урсгал зардал
1	Сумын дүн	46,133.2	40,847.0	-5,286.2	2,072.1	1,664.9	37,109.9
2	Аймгийн дүн	22,230.4	18,698.5	-3,531.9	0.0	3,332.9	15,365.6
	Дүн	68,363.6	59,545.5	-8,818.1	2,072.1	4,997.8	52,475.5

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 8,818.1 сая төгрөгийн хэмнэлт гарсан нь дараах зардлуудын гүйцэтгэлтэй холбоотой байна.Үүнд:

- Бараа, ажил үйлчилгээний зардал 1,620.4 сая төгрөг
- Урсгал шилжүүлэг 4,838.8 сая төгрөг
- Сум хөгжүүлэх сан 1,595.3 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 763.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 87.1 хувьтай байгаа нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж төсвийн зарцуулалтын зарим арга хэмжээнүүд хязгаарлагдсантай холбоотой байна.

Хүснэгт №-14. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулбал:

Зардлын нэр төрөл	2021 он	2022 он	Өөрчлөлт
Урсгал зардал	109,171.3	52,475.5	-56,695.8
Хөрөнгийн зардал	8,269.8	4,997.8	-3,272.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	1,124.8	2,072.1	947.3
Зардлын дүн	118,565.9	59,545.5	-59,020.4

2022 оны гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал зардал 56,695.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 3,272.0 сая төгрөгөөр буурч, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 947.3 сая төгрөгөөр өссөн байна.

Төсвийн зардал өмнөх оноос буурсан нь аймгийн Засаг даргын харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв гүйцэтгэлийг зардлын зүйлээр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-15 Төсвийн зарлагыг зардлын зүйлээр харуулбал

Зардлын зүйл	Жилийн төсөв	Гүйцэтгэл	/сая.төг/ Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,634.3	13,138.9	96.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,706.6	1,623.9	95.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,459.3	12,284.7	98.6
Хангамж, бараа материалын зардал	1,227.9	1,207.5	98.3
Норматив зардал	136.4	136.3	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1,635.6	1,590.4	97.2
Томилолт, зочны зардал	155.0	145.9	94.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,057.8	3,576.3	88.1
Бараа үйлчилгээний бусад зардал	3,787.7	3,476.8	91.8
Татаас	1,267.7	1,267.7	100.0
Урсгал шилжүүлэг	18,866.4	14,027.6	74.4
Хөрөнгийн зардал	5,761.5	4,997.8	86.8
Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт	3,667.4	2,072.1	56.5
НИЙТ ЗАРЛАГА	68,363.6	59,545.5	87.1

Цалин шимтгэлийн зардал 96.4 хувь, тогтмол зардал 98.6 хувь, хангамжийн зардал 98.3 хувь, норматив зардал 99.9 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 97.2 хувь, татаас шилжүүлэг 100 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 91.8 хувь, урсгал шилжүүлэг 74.4 хувь, хөрөнгийн зардал 86.8 хувь, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн олголт 56.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөвсгөл аймгийн 2022 оны зардлын төлөвлөгөө 68,363.6 сая төгрөг, гүйцэтгэл 59,545.5 сая төгрөг буюу 87.1 хувьтай байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар:

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 2,055.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,426.3 сая төгрөгийг эргэн төлүүлж 69.4 хувийн биелэлттэй байна. Хоршоо хөгжүүлэх сангаас 3,667.4 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 2,072.1 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн төлбөрт 100.6 сая төгрөгийг төлүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 132.4 сая төгрөгийг төлүүлж хэрэгжилт 131.6 хувийн биелэлттэй байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын эхний үлдэгдэл 3,898.9 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 629.3 сая төгрөгөөр нэмэгдэж 4,528.1 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 296 иргэнтэй холбоотой 1,227.9 сая төгрөгийн авлагатай байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 2,055.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,443.7 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлж, орлогын төлөвлөгөөг 612.2 сая төгрөг буюу 29.8 хувиар дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" батламж мэдээдлийг хангахгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлт гүйцэтгэлийн талаар:

Тайлант онд Орон нутгийн хөрөнгө төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжих 26, өмнөх оноос шилжиж ирсэн 1 нийт 27 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 2,979.2 сая төгрөгийн төлөвлөж 2,547.1 сая төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжиж 432.2 сая төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнүүд нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжгүй, зураг төсөвгүй нийтийн эрх ашигт нийцээгүй 190.0 сая төгрөгийн 2 төсөл, аргэ хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-16		/сая.төг/
№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/	100.0
2	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/	90.0
Нийт		190.0

Зураг, төсөвгүй 892.9 сая төгрөгийн хүснэгтэд заасан 9 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна. Үүнд:

хүснэгт №-17		/сая.төг/	
№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлснээс үүдэн 2023 онд Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/, Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/ гэсэн 2 төсөл, хэмжээнд 90.0 сая төгрөгийн төсвийг нэмж баталсан байна.
1	Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих	14.4	
2	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин, тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах	49.4	
3	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	50.0	
4	Мод тарьж, ногоон суварга босгоё аяны хүрээнд хашаа, хайс барих, шинэчлэх /Мөрөн сум 5 дугаар баг/	500.0	
5	Гудамж талбайн гэрэлтүүлэг, индрийн засвар арчлалт	30.0	
6	Газар чөлөөлөх Г байрыг буулгах /Далгэрмөрөн цогцолбор сургууль/Мөрөн сум/	19.8	
7	Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх /Мөрөн сум/	39.3	
Нийт		702.9	

Дээрх зөрчил нь тухайн онд тавьсан зорилт, үр дүнд хөрөнгө оруулалтаа чиглүүлж ажиллаагүй байгааг харуулж байна. Энэ талаар "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитаар холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар:

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Хүснэгт №-18 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулбал /сая.төгрөг/

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шилжих хөрөнгө оруулалт	35	4,460.1	35	3,927.4
2	Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт	22	2,942.6	21	1,997.5
3	аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт	7	1,123.8	7	1,055.6
4	Аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар	10	529.2	10	476.1
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих	18	8,994.0	18	7,366.9
6	Мал хамгаалах сан				
7	Зураг төслийн сан	32	564.6	32	409.2
8	Чанарын баталгааны барьцаа хөрөнгөөр хэрэгжих				
9	Захиалагчийн хяналтын зардлаар хэрэгжих				
10	Ажлын гүйцэтгэлээр хэрэгжих зураг, төсөл	15	176.9	15	176.4
Нийт		139	18,791.2	138	15,409.1

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 18,791.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 139 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөж, гүйцэтгэлээр 15,409.1 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулжээ.

Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг 199.6 сая төгрөгийн 5 мэдээллээр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ талаар "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитаар холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Мал хамгаалах сангийн гүйцэтгэл:

Аймгийн Мал хамгаалах сангийн батлагдсан төсөв 135.8 сая төгрөг, гүйцэтгэл 105.8 сая төгрөг болж орон нутгийн төсвөөс 93.0 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоо 3.2 сая төгрөг, урьд оны төвийн үлдэгдлээс 15.8 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлж, 105.6 сая төгрөг зарцуулж 7.0 сая төгрөг төсөвт буцааж төвлөрүүлсэн байна.

Түрээсийн орон сууцны сангийн төсвийн гүйцэтгэл:

Хөвсгөл аймгийн Засаг дарга "Шинэ Мөрөн" хорооллын 135 айлын орон сууц, 34 автомашины гараашийг худалдан авах гэрээг Монгол Улсын Хөгжлийн банкттай 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр үл хөдлөх эд хөрөнгийн үндсэн үнийг 9,549.6 сая төгрөг, хугацааг 5 жил, жилийн 6 хувийн хүү /авлагын үлдэгдлийн бодит үлдэгдлээс тооцох/, хуваарийн дагуу төлөөгүй хэтрүүлсэн зээлийн дүнгийн 0.1 хувиар 1 хоног тутам алданги, хагас жил тутам үндсэн төлбөрийг хүүгийн хамт төлөхөөр гэрээ байгуулсан байна.

Түрээсийн орон сууцны эргэлтийн сангийн хүүгийн төлбөрийг орон нутаг хариуцахаар шийдвэрлэн Хөгжлийн банкттай гэрээ хийвэл орон нутгийн төсөвт 2,087.4 сая төгрөгийн хүүгийн өр төлбөрийн дарамт үүсэхээр байна

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тогтоолоор МУ-ын Хөгжлийн банканд төлөх зээлийн эргэн төлөлтийг түр түдгэлзүүлсэнтэй холбоотой 2022 онд мөнгө шилжүүлээгүй Түрээсийн орон сууцны эргэлтийн сангийн дансанд 477.9 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Техникийн хяналтын зардлын талаар:

Аймгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээс тооцох техникийн хяналтын дансанд гүйцэтгэлээр орлого 230.5 сая төгрөг орж, 388.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Техник хяналтын данснаас Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хяналтыг хэрэгжүүлэхэд зориулж 109.8 сая төгрөгөөр автомашин худалдан авч тэвчиж болохуйц зардлыг гаргасан байна.

Бүтэц орон тооны талаар: Засаг даргын харьяа байгууллагуудад нийт 2,010 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 2,009 орон тоотой ажилласнаар нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

Хүснэгт №-17 Орон тооны мэдээлэл

№	Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Удирдах ажилтан	234	233	-1
2	Гүйцэтгэх ажилтан	416	412	-4
3	Үйлчлэх ажилтан	1,360	1,364	4
	Дүн	2,010	2,009	-1

Тайлант онд Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газар нь 1 гүйцэтгэх ажилтны орон тоогоор дутуу ажилласан байна.

Шүүхийн шийдвэр гарч ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь тогтоогдсон Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг төсвөөс олгож буруутай албан тушаалтнаас авах авлагаар бүртгэсэн хэдий ч байгууллагад учирсан хохирлыг барагдуулаагүйтэй холбоотой 115.2 сая төгрөгийн авлага байна. Авлагыг

барагдуулж ажиллахтай холбоотой зөвлөмжийг аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 475 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд гол нөлөө үзүүлэх үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг томоохон арга хэмжээнд төсөв батлаагүй байна. Энэ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь хэрэгжихгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг өөрийн үнэлгээгээр 2022 онд 78.8 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн биелэлт 87.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тодорхойлон нийт 24 хөтөлбөрийн хүрээнд зардлын зориулалт, арга хэмжээний ангиллаар 68,363.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, 59,545.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. /Хавсралт № 1-ээс харах/

Хөтөлбөрийн хэрэгжилт 87.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр 59.1 хувь, Авто зам 69.8 хувь, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний биелэлт 88.9 хувь, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт 73.9 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсвийн талаар: Тайлант онд дансны эхний үлдэгдлээс 267.4 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 461.5 сая төгрөгийг, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах нөөц сангаас 292.5 сая төгрөгийг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 1,007.1 сая төгрөгийг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 433.1 сая төгрөг, төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээлээс 59.5 сая төгрөг нийт 2,253.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт төсвийн санхүүжилтээс бараа ажил үйлчилгээний зардалд 1,867.8 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 653.4 сая төгрөг нийт 2,521.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсвийн байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэсэн байна.

Төсвийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулаагүйгээс 424.8 сая төгрөгийн зөрчил гаргасан байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс төрийн өмчлөлд бүртгэх боломжгүй, цөөн иргэдийн эрх ашгийг хөндсөн 190.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Мөрөн сумын 8 дугаар багийн 15, 16 дугаар байрны дээврийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.
- Эдийн засгийн ангилал зөрчиж 33.1 сая төгрөгийн зардал гаргасан
- Сургалт, хоолны зардалд 3.8 сая төгрөгийг зарцуулсан
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 197.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүйтэй холбоотой 573.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн хэдий ч аймгийн Засаг дарга төсвийн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажиллах талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулж ажиллаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 573.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. Засаг дарга дансны хөрөнгийг захиран зарцуулах эрх зүйн актгүй, бусад төсвийн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхцаж байна. Холбогдох төсвийн шууд захирагчид хамаарах боломжтой зардлыг тухайн дансаар дамжуулан төлөвлөж, төсвийн зардлыг үр ашиггүй зарцуулах боломж, нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал:

- ✓ Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэгт 80.0 сая төгрөг, хувь хүмүүст олгосон тусламж дэмжлэгт 56.3 сая төгрөг,
- ✓ Уралдаан тэмцээний зардал 10.8 сая төгрөг,
- ✓ бусад байгууллагуудын зохион байгуулсан хурал цуглааны зардалд 39.5 сая төгрөг,
- ✓ шагнал урамшууллын зардалд 60.3 сая төгрөг

Засаг дарга дансны төсвийн зарцуулалттай холбоотой нийт **246.9** сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохгүй байх заалтуудыг нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Засаг дансыг хаах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

2. Төсвийн шууд захирагчдын болон ТБОНӨААН-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт **326.6** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- ✓ Намын суудлын мөнгө гэж Аймгийн ИТХ 82.0 сая төгрөг, Мөрөн сумын ИТХ намын 31.0 сая төгрөг нийт 113.0 сая төгрөгийг олгосон.
- ✓ Төсийн хөрөнгөөр 19.8 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан
- ✓ Гар утас нэгж худалдан авсан зардалд 0.9 сая төгрөг
- ✓ Нутаг явах унааны зардалд 0.5 сая төгрөг
- ✓ Сургалт семинар, хурал зөвлөгөөний зардалд 60.8 сая төгрөг
- ✓ Хилийн цэс тогтоох хаалга барихад 21.3 сая төгрөг
- ✓ Авто машин ашиглах эрхгүй албан тушаалтан авто машин ашигласантай холбоотой 4.8 сая төгрөг.

Төсвийн шууд захирагчдын болон ТБОНӨААН-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохиох байгуулж ажилласан хэдий ч орон нутгийн төсвийн төлөвлөлт, хуваарилалт, орлого бүрдүүлэлт, болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс нь сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/29 тоот захирамжаар батлуулсан байна. Дотоод хяналтаар төрийн сангуудын хийж гүйцэтгэсэн гүйлгээнүүд, санхүүжилт болон тайлагналын хяналт, татварын орлогын бүрдүүлэлт, төлбөр тооцооны хяналт, төсвийн байгууллагын мөнгөн кассын хэрэгжилт, төрийн сангийн баримтын архивын нэгж бүрдүүлэлт зэрэгт хяналт хийж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүд нь төсвийн шууд захирагчдын ажил гүйлгээнд тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүйгээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 573.3 сая төгрөг, төсвийн зарцуулалттай холбоотой 424.8 сая төгрөгийн зөрчил гарсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дах заалтын дагуу иж бүрэн тайлагнасан байна. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийг харьяа байгууллагуудаар нэгтгэн тайлагнасан
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр зориулалтаар нь тайлагнасан

- Төсвийн гүйцэтгэлийг хөрөнгө оруулалтаар нь тайлагнасан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлбар тодруулгыг бэлтгэж ирүүлсэн

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн нэгтгэл, тайлагналтай холбоотой нийт 10,283.5 сая төгрөгийн алдааг илрүүлж, аудитын хугацаанд 10,243.8 сая төгрөгийн алдааг залруулж, 39.7 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг өмнөх оны эцсийн үлдэгдлээс 39.7 сая төгрөгөөр бага тайлагнасан.
- Төсвийн төлөвлөгөөний орлого, зардлын төлөвлөгөөний дүнг ИТХ-аар батлагдсан дүнгээс 243.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Сумдын давсан орлого, төсвийн зарцуулаагүй үлдэгдэл нийт 755.8 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхдээ тохируулах бичилт хийж цэвэр дүнгээр тайлагнаагүй.
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас /Улсын төсөв/ санхүүжсэн 8,812.6 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжсэн гэж алдаатай тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн хөрөнгө оруулалт данснаас төсөвт буцаан төвлөрүүлсэн 432.2 сая төгрөгийг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орон нутгийн төсвөөс санхүүжсэн дүнг бууруулж тохируулах бичилт хийгээгүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1 дэх заалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Сумын Эрүүл мэндийн төвүүд улсын төсөвт шилжихэд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Сангийн яамнаас тохируулга хийгээгүйтэй холбоотой 39.7 сая төгрөгийн алдааг залруулаагүй.

Төсвийн тэнцэл

Төсвийн тэнцэл = Орон нутгийн төсвийн орлого 20,951.8 сая төгрөг - Орон нутгийн төсвийн нийт зардал 58,934.8 сая төгрөг = -37,983.0 сая төгрөг.

Аудитаар илрүүлсэн алдааны талаар:

Аудитаар нийт 10,283.5 сая төгрөгийн Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой 5 алдаа илэрсэн. Аудитын хугацаанд бүртгэл тайлагналтай холбоотой нийт 10,243.8 сая төгрөгийн 4 алдааг залруулсан.

Сумын Эрүүл мэндийн төвүүд улсын төсөвт шилжихэд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Сангийн яамнаас тохируулга хийгээгүйтэй холбоотой 39.7 сая төгрөгийн 1 алдааг залруулаагүй.

Аудитаар илрүүлсэн зөрчлийн талаар.

Аудитаар илэрсэн нийт 3,661.7 сая төгрөгийн зөрчилд 246.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3,414.8 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 8 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийг бодит тооцоо судалгаа болон өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөөгүйгээс Сангийн яаманд хүргүүлсэн дүнгээс 8,945.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан шаардлагыг хангуулж төлөвлөхгүй байна.
3. Хөвсгөл аймгийн 2022 онд төсөвт 1 удаа тодотгол, 1 удаа зохицуулалт нийсэн нь холбогдох хууль, журамтай нийцэж байна.
4. Орон нутгийн орлогыг нийт дүнгээр 6,034.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн хэдий ч нэр төрлөөр нь хянаж үзэхэд 1,046.8 сая төгрөгөөр тасалсан, 282.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан нь орлогын биелэлтэд жигд анхаарч ажиллаагүй, шинээр хэрэгжиж байгаа хууль журмын дагуу орон нутгийн орлогод оруулж болох орлогыг Сангийн яам болон Татварын ерөнхий газартай тухай бүр тооцоо нийлж, бүрэн төвлөрүүлж чадаагүй байна.
5. Төсвийн үр ашгийг дээшлүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар аймгийн Засаг даргаас бодитой ажил төлөвлөж хэрэгжүүлээгүй байна. Үүнээс шалтгаалан аудитаар төсвийг үр ашиггүй байдлаар зарцуулсан нийт 1,010.4 сая төгрөгийн зөрчил илэрч байна.
6. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын албанаас төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон төвийн үр ашгийг дээшлүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тодорхой хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил буурахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан-д:

1. Төсвийг бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл болон шинээр хэрэгжиж байгаа хууль журамд нийцүүлэн, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж Сангийн яаманд санал хүргүүлэх
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөх
3. Орон нутгийн орлогыг нэр төрөл бүрээр гүйцэтгэлийг жигд ханган ажиллахад анхаарч, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байгаа төсвийн төвлөрүүлэн захирагч нартай хариуцлага тооцон ажиллах
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базарт:

1. Төсвийг бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл болон шинээр хэрэгжиж байгаа хууль журамд нийцүүлэн, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж Сангийн яаманд санал хүргүүлэх
2. Орон нутгийн орлогыг нэр төрөл бүрээр гүйцэтгэлийг жигд ханган ажиллах, Сангийн яам болон Татварын ерөнхий газартай тооцоо нийлж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдахгүй байх.
3. Санхүү төрийн сангийн хэлтсээс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл түүний хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Санхүүгийн хяналт аудитын албаны даргыг түр орлон гүйцэтгэгч:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл түүний хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	5	10,283,500.0			5	10,283,500.0	4	10,283.5	1	37,900.0
Дүн	5	10,283,500.0			5	10,283,500.0	4	10,283.5	1	37,900.0

Зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ААН-ийн орлогын албан татварын орлогыг 2,720.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 1,170.0 сая төгрөг буюу 43.0 хувийг аймгийн төсөвт, 1,550.0 сая төгрөг буюу 57.0 хувийг улсын төсөвт хуваарилахвар тусгасан байна. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 3 хувиар буюу 18.0 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.	1	18,000.0					1	18,000.0
Гүйцэтгэлээр ААН-ийн орлогын албан татварын 2,462.4 сая төгрөгийн орлого орж 936.0 сая төгрөг буюу 38.0 хувийг аймгийн төсөвт, 1,526.4 сая төгрөг буюу 62.0 хувийг улсын төсвийн орлогод хуваарилсан байна. Аймгийн төсөвт хуваарилах дүнг 2 хувиар буюу 50.0 сая төгрөгөөр дутуу хүлээн авсан байна.	1	50,000.0					1	50,000.0
Тайлант онд Төсвийн тухай хуульд заасны дагуу Мөрөн сумын төсөвт төвлөрөх ёстой Хаан банкны нийт хувьцаа эзэмшигчдэдээ хувьцааны ногдол ашиг олгосон орлогоос суутгасан 232.2 сая төгрөгийн ХХОАТ-ыг "Суутгасан ААНОАТ" нэрээр улсын төсөвт төвлөрүүлсэн байна.	1	232,200.0					1	232,200.0
Засаг дарга дvнснv хөрөнгийг захиран зарцуулах эрх зvйн актгvй, бусад төсвийн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхцаж байна. Холбогдох төсвийн шууд захирагчид хамаарах боломжтой зардлыг тухайн дансаар дамжуулан төлөвлөж, төсвийн зардлыг үр ашиггүй зарцуулах боломж нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал: Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэгт 80.0 сая төгрөг, хувь хүмүүст олгосон тусламж дэмжлэгт 56.3 сая төгрөг, Уралдаан тэмцээний зардал 10.8 сая төгрөг, бусад байгууллагуудын зохион байгуулсан хурал цуглааны зардалд 39.5 сая төгрөг, шагнал урамшууллын зардалд 60.3 сая төгрөг нийт 246.9 сая төгрөгийг зарцуулсан	1	246,900.0			1	246,900.0		

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжгүй 190.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн.	1	190,000.0		1	190,000.0
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтад туссан шаардлагыг бүрэн хангаагүй зураг төсөвгүй 9 төсөл арга хэмжээг төлөвлөсөн	1	702,900.0		1	702,900.0
Орон нутгийн нийт 26 нэр төрлийн орлогоос 7 нэр төрлийн 1,046.8 сая төгрөгийн орлогыг тасалсан байна.	1	1,046,800.0		1	1,046,800.0
Хөвсгөл аймгийн хэмжээнд Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн талалтийг 2,055.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,443.7 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлж, орлогын төлөвлөгөөг 612.2 сая төгрөг буюу 29.8 хувиар дутуу төвлөрүүлсэн байна	1	612,200.0		1	612,200.0
Төсвийн зарцуулалт болон төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 562.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	1	562,730.3		1	562,730.3
Дүн	9	3,661,730.3		1	246,900.0
				8	3,414,830.3

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөөлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/Мян.төг/
					Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,363,614.9	59,545,471.2	8,818,143.7	87.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,934,758.3	52,475,541.4	6,459,216.9	89.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,800,634.9	37,180,261.3	1,620,373.6	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,634,292.1	13,138,910.5	495,381.6	96.4
210101	Үндсэн цалин	11,645,931.9	10,611,514.1	1,034,417.8	91.1
210102	Нэмэгдэл	1,349,434.4	1,712,353.7	-362,919.3	126.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,881.7	188,037.5	27,844.2	87.1
210104	Урамшуулал	361,389.4	588,935.0	-227,545.6	163.0
210105	Гэрээт ажлын хөлс	61,654.7	38,070.1	23,584.6	61.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,706,580.3	1,623,863.9	82,716.4	95.2
210201	Тэтгэврийн даатгал	1,165,422.8	1,106,955.6	58,467.2	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	142,220.8	134,038.5	8,182.3	94.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	106,441.9	102,476.7	3,965.2	96.3
210204	Ажилгүйдлийн даатгал	26,947.9	25,959.5	988.4	96.3
210205	Эрүүл мэндийн даатгал	265,546.9	254,433.6	11,113.3	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,459,285.5	12,284,678.9	174,606.6	98.6
210301	Гэрэл, цахилгаан	872,212.1	807,868.0	64,344.1	92.6
210302	Түлш, халаалт	11,098,570.4	11,031,627.9	66,942.5	99.4
210303	Цэвэр, бохир ус	488,503.0	445,183.0	43,320.0	91.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,227,976.2	1,207,295.1	20,681.1	98.3
210401	Бичиг хэрэг	176,565.6	176,833.5	-267.9	100.2
210402	Тээвэр, шатахуун	722,685.8	714,576.6	8,109.2	98.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	122,726.4	114,856.2	7,870.2	93.6
210404	Ном, хэвлэл	17,461.1	14,424.6	3,036.5	82.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,613.0	57,785.1	2,827.9	95.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	127,924.3	128,819.0	-894.7	100.7
2105	Нормативт зардал	136,391.6	136,286.6	105.0	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,458.5	1,458.5	0.0	100.0
210502	Хоол, хүнс	97,183.1	97,183.1	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	37,750.0	37,645.0	105.0	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,635,553.5	1,590,156.1	45,397.4	97.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,414.8	141,517.5	8,897.3	94.1
210602	Тавилга	38,041.1	37,980.1	61.0	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000.0	1,500.0	1,500.0	50.0
210604	Урсгал засвар	1,444,097.6	1,409,158.5	34,939.1	97.6
2107	Томиллолт, зочны зардал	155,031.8	145,976.8	9,055.0	94.2
210702	Дотоод албан томиллолт	153,031.8	143,976.8	9,055.0	94.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000.0	2,000.0	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,057,825.9	3,576,287.8	481,538.1	88.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,984,215.9	3,511,908.5	472,307.4	88.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,767.4	2,297.4	1,470.0	61.0
210803	Даатгалын үйлчилгээ	8,260.9	7,436.3	824.6	90.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,513.3	5,492.5	1,020.9	84.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,677.5	1,902.8	774.7	71.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,046.5	34,422.8	2,623.8	92.9

210807	Газрын төлбөр	15,344.4	12,827.6	2,516.8	83.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,787,698.0	3,476,805.7	310,892.3	91.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,552,449.2	3,263,923.0	288,526.2	91.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	235,248.8	212,882.6	22,366.2	90.5
212	ТАТААС	1,267,680.1	1,267,680.1	0.0	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,062,694.9	1,062,694.9	0.0	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,062,694.9	1,062,694.9	0.0	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	204,985.2	204,985.2	0.0	100.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	204,985.2	204,985.2	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,866,443.3	14,027,600.0	4,838,843.3	74.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,755,978.7	11,981,751.7	4,774,227.0	71.5
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,755,978.7	11,981,751.7	4,774,227.0	71.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,110,464.6	2,045,848.3	64,616.3	96.9
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	962,596.0	962,545.2	50.8	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	92,866.2	89,842.3	3,023.9	96.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	590,681.8	572,304.0	18,377.8	96.9
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	160.0	0.0	160.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	267,471.4	232,905.8	34,565.6	87.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,689.2	188,251.1	8,438.1	95.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,761,481.7	4,997,829.8	763,651.9	86.7
221001	Их засвар	60,000.0	55,358.8	4,641.2	92.3
223001	Бусад хөрөнгө	5,701,481.7	4,942,471.1	759,010.6	86.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,667,374.9	2,072,100.0	1,595,274.9	56.5
230001	Эргэж төлөгдөх зээл	3,667,374.9	2,072,100.0	1,595,274.9	56.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	68,363,614.9	58,342,863.9	10,020,751.0	85.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,822,960.6	9,106,834.9	-283,874.3	103.2
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	8,822,960.6	9,106,834.9	-283,874.3	103.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,765,087.8	46,966,138.4	-3,201,050.6	107.3
320001	Орон нутгийн төсвөөс	43,765,087.8	46,966,138.4	-3,201,050.6	107.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,775,566.5	2,269,890.6	13,505,675.9	14.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,130,436.5	1,949,278.9	181,157.6	91.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,603.4	133,380.5	-32,777.1	132.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	13,544,526.6	187,231.2	13,357,295.4	1.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	6,641,343.0	-6,641,343.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	5,438,735.7	-5,438,735.7	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	2,010	2,009	1	100.0
620001	Удирдах ажилтан	234	233	1	99.6
620002	Гүйцэтгэх ажилтан	416	412	4	99.0
620003	Үйлчлэх ажилтан	1,360	1,364	-4	100.3

Нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /мян.төг/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,521,183.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,521,183.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,867,787.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,089.0
210101	Үндсэн цалин	4,142.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	210.0
210104	Урамшуулал	9,724.0
210105	Гэрээт ажлын хөлс	28,012.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,925.9
210201	Тэтгэврийн даатгал	3,847.8
210202	Тэтгэмжийн даатгал	19.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	15.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3.9
210205	Эрүүл мэндийн даатгал	39.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,178.8
210301	Гэрэл, цахилгаан	3,531.8
210302	Түлш, халаалт	3,270.0
210303	Цэвэр, бохир ус	1,377.0
2104	Хангамж, бараа материалын зардал	121,701.0
210401	Бичиг хэрэг	11,929.7
210402	Тээвэр, шатахуун	88,435.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	732.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,603.1
2105	Нормативт зардал	98,458.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,554.2
210502	Хоол, хүнс	92,904.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,538.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,256.0
210602	Тавилга	11,886.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,075.0
210604	Урсгал засвар	38,321.2
2107	Томилолт, зочны зардал	140.0
210702	Дотоод албан томилолт	140.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,204,873.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,204,873.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	327,881.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,860.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,021.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	653,396.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,620.3
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,620.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	423,424.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	423,424.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	214,352.5
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	93,589.4
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	37,801.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	82,961.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,253,794.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,253,794.1

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	461,541.2
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	59,492.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	292,540.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,007,105.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	433,113.8
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-267,389.9
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	267,544.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	154.7

Хавсралт №-1

Хөтөлбөрийн хэрэгжилт

				/мян.төг/
№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Авто зам	1,104,520.5	770,801.0	69.8
2	Ангилагдаагүй бусад	147,830.7	147,830.7	100.0
3	Ахмад настны хөгжил хамгаалал	60,297.5	60,297.5	100.0
4	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	1,470,007.5	1,306,744.7	88.9
5	Биеийн тамир спорт	234,606.8	231,543.9	98.7
6	Газрын зураглал, кадастр	204,985.2	204,985.2	100.0
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	354,206.4	341,584.3	96.4
8	Ерөнхий боловсрол	9,449,328.7	9,344,413.2	98.9
9	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	3,734,428.6	2,206,799.2	59.1
10	Мал аж ахуйг хөгжүүлэх	643,970.4	609,635.0	94.7
11	Насан туршийн болон албан бус боловсрол	11,656.7	11,656.7	100.0
12	Нийгмийн халамж	1,403,992.6	1,403,941.5	100.0
13	Ойжуулалт	155,126.5	155,126.5	100.0
14	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2,600,768.3	2,520,254.9	96.9
15	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	17,279,072.9	16,247,604.1	94.0
16	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	20,491,436.9	15,150,353.3	73.9
17	Соёл урлаг	1,560,559.1	1,531,927.7	98.2
18	Сургуулийн өмнөх боловсрол	3,325,482.9	3,239,927.9	97.4
19	Суурин газрын усан хангамж	285,800.0	285,799.7	100.0
20	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	233,859.5	227,037.0	97.1
21	Тусгай хэрэгцээт боловсрол	243,231.8	242,449.8	99.7
22	Хот байгуулалт, тохижилт	1,257,593.2	1,257,593.2	100.0
23	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	969,128.5	927,179.2	95.7
24	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,141,723.7	1,119,985.2	98.1
	НИЙТ ДҮН	68,363,614.9	59,545,471.2	87.1

Хавсралт №-2

Орон нутгийн 2022 оны төсвийн орлогын гүйцэтгэл

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйц хувь
ОРОН НУТГИЙН ОРЛОГО	22,172,009.4	28,206,523.6	6,034,514.2	127%
Татварын орлого	19,365,377.1	24,754,184.8	5,388,807.7	128%
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	9,852,493.4	11,016,235.2	1,163,741.8	112%
1 Үйл ажиллагааны орлого	511,344.0	774,252.3	262,908.3	151%
3 Хадгаламжийн хүүгийн татварын орлого	1,798,579.9	1,301,267.1	-497,312.8	72%
4 Хөрөнгө борлуулсны орлого	344,821.5	417,868.3	73,046.8	121%
5 Шууд бус орлого	356,600.0	992,281.9	635,681.9	278%
6 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,038,420.3	-910,750.5	127,669.8	88%
7 ААН-ын орлогын албан татвар	1,170,000.0	936,000.0	-234,000.0	80%
8 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	498,309.0	585,420.1	87,111.1	117%
9 Бууны албан татвар	81,786.0	81,191.2	-594.8	99%
10 Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	680,000.0	857,299.1	177,299.1	126%
11 Малд ногдуулах албан татвар	1,587,869.6	1,406,032.7	-181,836.9	89%
12 Улсын тэмдэгтийн хураамж	498,803.5	647,346.2	148,542.7	130%
13 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	44,277.5	54,149.7	9,872.2	122%
14 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	463,839.2	333,248.9	-130,590.3	72%
15 Газрын төлбөр	442,299.1	501,245.0	58,945.9	113%
16 Дуудлага худалдаа	67,401.7	262,356.8	194,955.1	389%
17 Ойн нөөц ашигласны төлбөр	1,741,878.9	4,982,907.5	3,241,028.6	286%
18 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	181,494.1	424,856.8	243,362.7	234%
19 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	56,780.0	62,308.5	5,528.5	110%
20 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	25,220.0	25,184.6	-35.4	100%
21 Бусад татвар	0.0	3,483.6	3,483.6	
Татварын бус орлого	1,586,395.10	2,194,138.41	607,743.3	138%
1 Хувьцааны ногдол ашиг	267,000.0	275,864.3	8,864.3	103%
2 Торгуулийн орлого	936,411.0	1,453,688.4	517,277.4	155%
3 Түрээсийн орлого	44,284.1	41,815.0	-2,469.1	94%
4 Бусад орлого	338,700.0	422,770.7	84,070.7	125%
Хөрөнгийн орлого	1,220,237.2	1,258,200.3	37,963.1	103%
1 Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	1,220,237.2	1,258,200.3	37,963.1	103%

Хавсралт №-3

Сумын 2022 оны орлогын гүйцэтгэл

/мян.төг/

Сумын нэр	2022 оны жилийн эцэс		Давалт, тасралт	Гүйцэтгэл
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Алаг-Эрдэнэ	358,900.0	403,500.0	44,600.0	112%
Арбулаг	338,400.0	338,000.0	(400.0)	100%
Баянзүрх	326,800.0	395,000.0	68,200.0	121%
Бүрэнтогтох	395,200.0	469,000.0	73,800.0	119%
Галт	470,600.0	652,000.0	181,400.0	139%
Жаргалант	475,900.0	676,900.0	201,000.0	142%
Их-Уул	409,700.0	497,200.0	87,500.0	121%
Рашаант	343,700.0	392,300.0	48,600.0	114%
Ренчинлхүмбэ	491,800.0	1,177,100.0	685,300.0	239%
Тариалан	618,600.0	1,122,500.0	503,900.0	181%
Тосонцэнгэл	340,000.0	398,400.0	58,400.0	117%
Төмөрбулаг	338,200.0	289,700.0	(48,500.0)	86%
Түнэл	347,400.0	450,600.0	103,200.0	130%
Улаан-Уул	378,600.0	390,600.0	12,000.0	103%
Ханх	254,800.0	290,800.0	36,000.0	114%
Цагаан-Уул	584,900.0	733,500.0	148,600.0	125%
Цагаан-үүр	308,300.0	1,264,600.0	956,300.0	410%
Цэцэрлэг	415,800.0	571,600.0	155,800.0	137%
Чандмань-өндөр	377,100.0	637,300.0	260,200.0	169%
Шинэ-Идэр	304,400.0	319,600.0	15,200.0	105%
Хатгал	446,800.0	535,600.0	88,800.0	120%
Мөрөн	8,983,700.0	9,143,700.0	160,000.0	102%
Эрдэнэбулган	381,500.0	1,992,600.0	1,611,100.0	522%
Цагааннуур	178,300.0	244,800.0	66,500.0	137%
Орлогын дүн	17,869,400.0	23,386,900.0	5,517,500.0	131%

Хавсралт №-4

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл


№	Байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Зөрчлийн дүн /мян.төг/
1	Төмөрбулаг сумын ТТЗ	Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь 100.600.000 төгрөгөөр тасалсан	100,600.0
2	Цэцэрлэг сумын ТТЗ	Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь нийт 18.8 сая төгрөгөөр тасалсан байна.	18,800.0
3	Хатгал тосгоны ТТЗ	Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь нийт 27.2 сая төгрөгөөр тасалсан байна.	27,200.0
4	Чандмань-Өндөр сумын ТТЗ	Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь нийт 32.7 сая төгрөгөөр тасалсан байна.	32,700.0
5	Цагаан-Уул сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 5 нэр төрлийн 35.9 сая төгрөгийн орлогыг дутуу бүрдүүлсэн байна.	35,912.1
6	Алаг-Эрдэнэ сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 5 нэр төрлийн 33.4 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	33,543.1
7	Тосонцэнгэл сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 5 нэр төрлийн 13.4 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	13,400.0
8	Арбулаг сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 8 нэр төрлийн 87.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	87,500.0
9	Баянзүрх сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 8 нэр төрлийн 55.6 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	55,600.0
10	Рашаант сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 9 нэр төрлийн 24.1 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	24,100.0
11	Шинэ-Идэр сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 7 нэр төрлийн 20.6 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	20,600.0
12	Галт сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 12 нэр төрлийн 71.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	71,500.0
13	Эрдэнэбулган сумын ТТЗ	Улс, аймаг, сумын татварын орлогын төлөвлөгөөнөөс 10 нэр төрөл дутуу биелсэн.	20,400.0
14	Их-Уул сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн	67,500.0
15	Цагааннуур сумын ТТЗ	Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь 13.8 сая төгрөгөөр тасалсан	13,783.1
16	Мөрөн сумын ТТЗ	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 1,120.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 1,239.3 сая төгрөгөөр тасарсан байна.	1,239,189.0
17	Цагаан-Үүр сумын ТТЗ	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 953.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 28.4 сая төгрөгөөр тасарсан байна.	28,348.2
18	Тариалан сумын ТТЗ	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 510.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 24.0 сая төгрөгөөр тасарсан байна.	23,958.6
19	Бүрэнтогтох сумын ТТЗ	Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь 8.629.499 төгрөгөөр тасалсан	8,629.5
20	Жаргалант сумын ТТЗ	Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь нийт 46,026,526.1 сая төгрөгөөр тасалсан байна.	46,026.5
21	Ханх сумын ТТЗ	Тайлант оны улс орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь нийт 22.8 сая төгрөгөөр тасалсан байна.	22,873.6
22	Түнэл сумын ТТЗ	Улс, аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь 8.600.000 төгрөгөөр тасалсан	8,600.0

23	Улаан-Уул сумын ТТЗ	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь 36,500,000 төгрөгөөр тасалсан	36,500.0
24	Ренчинлхүмбэ сумын ТТЗ	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь 30,300,000 төгрөгөөр тасалсан	30,300.0
25	Алаг-Эрдэнэ сумын ТТЗ	Хоршоо хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн 223.5 сая төгрөгийн зээлийг олгоогүй байна.	223,500.0
26	Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих дүнг 38,867.1 мянган төгрөгөөр бага, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 38,867.1 мянган төгрөгөөр их дүнгээр үзүүлэлт хооронд гүйлгэж алдаатай тайлагнасан байна.	38,867.1
27		Төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,312.9 мянган төгрөгийн орлогын залруулгын гүйлгээг өөрийн орлого гэж тайлагнасан байна.	4,312.9
28	Цэцэрлэг сумын ЗДТГ	• Байгууллагын төсвөөс 230.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан. • Эпшиглэнт-Үйлс ХХК-д 500.0 мянган төгрөгийг шилжүүлж 2000 төгрөгийн хоноггүй 250 нэгжийн карт худалдан авч зарцуулсан	730.0
29		Цэцэрлэг сумын Хүн эмнэлгийн хэрэгцээнд гэж ЗДТГ-ын хөрөнгийн зардалд 88,000.0 мянган төгрөгийг тусган батлуулж 88,000.0 мянган төгрөгөөр toyta land cruiser grado-150 маркийн авто машиныг худалдан авсан байна. Тус сумын хүн эмнэлэгт авто машиныг сумын ИТХ-ын тогтоолоор шилжүүлсэн боловч авто машиныг ЗДТГ ашиглаж байна	88,000.0
30	Аймгийн ИТХ	Бүсийн сургалтын арга хэмжээний зардалд 3,182.8 мянган төгрөгийн хүнс бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	3,182.8
31		Орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй зардал гарган намын суудлын мөнгө гэж Ардчилсан намд 44,000.0 мянган төгрөг, Монгол ардын намд 36,000.0 мянган төгрөг, Д.Лхагвасүрэнд 2,000.0 мянган төгрөг нийт 82,000.0 мянган төгрөгийг олгосон	82,000.0
32		Байгууллагын төсвөөс 775.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	775.0
33		Байгууллагын төсвөөс төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардалд 2,437.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	2,437.0
34	Чандмань-Өндөр сумын ЗДТГ	• Байгууллагын төсвөөс 927.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	927.0
35	Чандмань-Өндөр сумын ИТХ	Байгууллагын төсвөөс 240,000 /хоёр зуун дөчин мянга/ төгрөгийг гар утасны зардалд зарцуулсан байна.	240.0
36	Цагаан-Уул сумын ЗДТГ	Хэвлэл захиалгын төлбөр 31.2 мянган төгрөг төлсөн байна.	31.2
37	Цагаан-Уул сумын ИТХ	Байгууллагын төсвөөс 267,300 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, 151,520 төгрөгийн хэвлэл захиалгын төлбөр төлсөн байна.	418.8
38	Хатгал тосгоны ЗАА	Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	678.6
39	Арбулаг сумын ЗДТГ	Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж 1,188,000.0 төгрөгийг зарцуулсан байна.	1,188.0
40	Баянзүрх сумын ЗДТГ	Санхүү албаны даргын 86410103 дугаарын интернэтийн төлбөр болох 25.0 мянган төгрөг, бүсийн тэмцээнд оролцсон хүмүүсийн хоолны зардал болох 232.0 мянган төгрөг, нийт 257.0 мянган төгрөгийг төлсөн байна.	257.0
41	Арбулаг ИТХ	Байгууллагын төсвөөс тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, сумын ИТХ-ын 22 төлөөлөгчийн зөвлөгөөнд оролцсон зардал болох 1,980,000.0 төгрөгийг төлсөн байна.	1,980.0
42	Баянзүрх сумын ИТХ	Байгууллагын төсвөөс тус сумын ИТХ-ын дарга Л.Доржпүрэв, ИТХ-ын нарийн бичгийн дарга Х.Адилмаа нарын гар утасны төлбөр болох 459,350.0 төгрөгийн зардлыг төлсөн байна.	459.4

43	Баянзүрх Соёлын төв	Байгууллагын төсвөөс бүсийн тэмцээнд оролцсон хүмүүсийн хоолны зардал болох 165000 төгрөгийг төлсөн байна.	165.0
44	Шинэ-Идэр сумын ИТХ	Байгууллагын төсвөөс тус сумын ИТХ-ын дарга Т.Гомбосүрэн 90,000.0 төгрөгийг, ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Гэрэлчулуун 210,000.0 төгрөгийн нэгжийн төлбөрийг төлсөн байна.	300.0
45		Нэгжийн төлбөрт 700.0 мянган төгрөг төлсөн байна	700.0
46	Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ	Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 4,882.1 мянган төгрөг, сахиул ажиллуулсан цалин урамшуулалд 2,400.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.	7,282.0
47	Алаг-Эрдэнэ сумын ИТХ	3,660,716 төгрөгийн нэг удаагийн шинжтэй тэтгэмж урамшууллыг цалингийн сангаас олгосон байна. Тэтгэмж олгосон захирамж нь хүчингүй болсон, хамааралгүй хууль эрх зүйн заалтыг үндэслэл болгосон байна.	3,660.7
48	Тосонцэнгэл сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,785.5 мянган төгрөгийг картын дансаар дамжуулан бэлнээр авч зарцуулсан байна.	20,785.6
49	Тосонцэнгэл сумын ИТХ	Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлаас 6,998,000 төгрөгийн хүнсний материал бэлтгэж, хурал сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан байна.	6,998.0
50	Тосонцэнгэл сумын ИТХ	Хичээл үйлдвэрлэлийн зардлаас ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний 412,500 төгрөгийг зарцуулсан байна.	412.5
51	Тосонцэнгэл сумын Соёлын төв	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 264360 төгрөгийн материал бэлтгэсэн байна.	264.4
52		Аймгийн Засаг даргын захирамжаар 85-аас 90 насны 312 ахмадуудад Аймгийн Засаг даргын гарын бэлгийг хүргүүлсэн байна.	8,564.4
53		Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээний хоолны зардалд 49,181,300.0 төгрөгийг зарцуулсан байна.	49,181.3
54	Аймгийн ЗДТГ	Улаанбаатар хот болон бусад газарт ажиллахдаа Албан ажлын томилолт, удирдамж, ажлын тайлангүйгээр 1,405,800 төгрөгийн шатахууны зардал гаргасан байна.	1,405.8
55		Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй автомашиныг аймгийн Засаг даргаас бусад албан тушаалтан дотор үйлчилгээнд ашигласан байна.	673.4
56		Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн байна.	3,903.8
57		Суурин утасны төлбөр 249,559.0 төгрөгийг тээвэр шатахууны зардлаас шилжүүлсэн байна.	249.6
58	Мөрөн сумын ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр сумын Тэргүүний тэмдэг, сумын хүндэт тэмдэг, жуух бичиг, тууз гэсэн 11,280,000.0 төгрөгийн үнэ бүхий зүйлсийг нөөцөлсөн байна.	11,280.0
59		Багийн засаг дарга нар багт ажиллахаар 4,156,950.0 төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.	4,157.0
60	Мөрөн сумын ИТХ	Намд суудлын мөнгө олгосон байна.	31,000.0
61	Цагааннуур сумын ЗДТГ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрөөс 181,500.0 төгрөгийн интернэтийн төлбөр төлсөн байна.	181.5
62	Цагаан-Үүр сумын ЗДТГ	Ном хэвлэлийн зардлаас 560,000.0 мянган төгрөг бичиг хэргийн материал худалдан авсан байна.	560.0
63	Цагаан-Үүр сумын ЗДТГ	Төсвөөс тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамаарахгүй дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна.	36,552.5
64	Жаргалант сумын ЗДТГ	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 21.2 сая төгрөгөөр хилийн цэсийн самбар, хаалга барьж байгуулахад зарцуулсан.	21,251.7

65		Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1.9 сая төгрөгийг байгууллагын халаалтын зардалд, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн зүйлс худалдан авах зардлаас 0,8 сая төгрөгийг мотоциклийн үнийн үлдэгдэлд төлсөн байна.	2,703.6
66	Бүрэнтогтох сумын ЗДТГ	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан өөрийн орлогын төлөвлөгөө 1.5 сая төгрөг ба гүйцэтгэл 1.9 сая төгрөг 0.4 сая төгрөгийг давуулан биелүүлсэн байна. Давсан орлогыг зарцуулж батлагдсан төсвийг 0,4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан	425.0
67		Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хянан үзэхэд Хөвсгөл ус сувгаас төрөөс хариуцах цэвэр бохир усны хөнгөлөлтийн орлого 8.2 сая төгрөг, тус сумын нутаг дэвсгэрт байрлах Нүүрстэйн уурхайгаас Хөвсгөл дулааны станцад нүүрс борлуулан 32.7 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан	40,901.6
68	Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 0.2 сая төгрөгөөр байгууллагын үндсэн үйл ажиллагаанд шаардлагагүй хоол хүнс, бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн зөрчил илэрсэн болно	223.1
69	Түнэл ЗДТГ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас ЗДТГ-ын А/54 тоот тушаалын дагуу шинэ байрны нээлтийн бэлэг /мөнгөн аяганы үнэ/ Анарпринт ХХК-д 850,000 төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулсан	850.0
70		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4,251,480.0 төгрөгийн халаалтын зардал Түнэл-Илч ХХК-д , байрны нээлтийн хоолны үнэ 405,400, Хатан түнэл ХХК-д 1,064,400 төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.	5,721.3
71	Эрдэнэбулган ЗДТГ	Тайлант онд 8,700,000 төгрөгийн шатахууны зардлыг түлж халаалтын зардлаар бүртгэж, тайлагнасан байна.	8,700.0
72	Галт ЗДТГ	Засаг даргын Тамгын газар нь НДШ-ийн зардал, нэг удаагийн шагнал, урамшууллыг цалингийн зардлаас зарцуулсан байна.	2,886.1
73	Их-Уул ЗДТГ	Туслах үйл ажиллагаа болох спорт зааланд арга зүйч, үйлчлэгчээр 2 хүнийг гэрээгээр ажиллуулж 599,426 төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлаас зарцуулсан байна.	599.4
74	Тэсийн-Илч ХХК	Байгууллагын төсвөөс 731,500 төгрөгийн гар бөмбөгийн тэмцээний хувцас, архи, шампанск худалдан авч ажилтнуудад олгосон байна.	731.5
75	Могойн гол ХХК	Уул уурхайн 100 жил, Могойн гол ХК-ийн 50 жилийн ой тэмдэглэх болон шинэ жилийн арга хэмжээний зардалд 88.9 сая төгрөг зарцуулж, компанийн хөрөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулсан	88,973.6
76	Түнэл-Илч ХХК	Төсвийн хөрөнгөөр 957.500 төгрөгөөр бэлэг бэлтгэсэн	957.5
77		Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөнд баяр ёслол тэмдэглэхтэй холбоотой зардлуудыг төлөвлөж, батлуулан 4,685,700.00 төгрөгийг зарцуулсан байна.	4,685.7
78	Хөвсгөл Эрчим хүч ХХК	Хөвсгөл аймгийн ИТХ-аас Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэнийг компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 сарын 15-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоолоор баталж, Хөвсгөл Бренд Экспо ХХК-д 11,000,000.00 төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.	11,000.0
79		Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ажилтан Л.Дариймаад ээлжийн амралтаараа төрсөн нутагтаа амрах ирэх, очих унааны зардлыг 538,000.00 төгрөгөөр тооцож олгосон байна.	538.0
Дүн			2,896,974.0

Байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар:

Ирүүлсэн санал тайлбар	Хариу тайлбар
<p style="text-align: center;"> ХӨВСГӨЛ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</p> <p style="text-align: center;">Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай</p> <p>Аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Засаг дарга дансыг хаахвас бусад асуудалтай санал нэг байгаагаас гадна зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p> <p>Харин Засаг дарга дансны тухайд: Холбогдох төсөв захирагчгүй зардлыг “Засаг дарга” данс нээж түүгээр дамжуулан батлах, зарцуулах чиглэлийг Сангийн яамнаас 2015 онд ирүүлсний дагуу /Сангийн сайдын албан бичиг хавсралт хүргэгдэж байсан/ энэ данс нээгдаж ашиглагдаж эхэлсэн. Сангийн яамнаас энэ дансыг хаах тухай шаардлага тавьдаггүйгээс гадна холбогдох төсөв захирагчгүй буюу аймгийн замын сан, ахмадын хороо, усны алдагдалын татаас, цэвэрлэх байгууламжын тогтмол зардал, мал эмнэлэгийн үйлчилгээний зардал, вакцены төлбөр, агаарын бохирдол бууруулах, нийтийн тээврийн татаас зардал зэрэг зардлууд энэ дансанд батлагдаж ирдэг, гүйцэтгэл гардаг хэвээрээ байгаа тул энэ дансыг хаах тухай албан шаардлага ирсэн нөхцөлд хэрэгжүүлэх боломжгүй байдал үүсэхээр байна.</p> <p>Иймд данс хаах тухай албан шаардлагыг зөрэгээр өөрчлүүлэх саналтай байна.</p> <p style="text-align: center;">САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.БАЗАР</p> <p style="text-align: right;">371.668.811</p>	<p>Хуулийн үндэслэлтэй санал, тайлбар ирүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.</p>